

**ПАРТИЗАН ЛУВСАНГИЙН ГОМБОЖАВ
(Түүхэн тэмдэглэл)**

Академич Ж.Болдбаатар

XX зуун Монголын тусгаар тогтнолыг дахин сэргээхийн төлөө тэмцсэн олон зуун хүмүүнийг төрүүлжээ. Тэдний нэг нь партизан Лувсангийн Гомбожав бүлгээ. Тэрбээр 1877 онд Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуунд (эдүгээгийн Дорноговь аймгийн Хатанбулаг) эцэг, эхийн насан идэрт мэндэлжээ.

Л.Гомбожав бага наснаасаа нутгийн оточийг дагаж, эмийн ургамал түүх, хатаах, нүдэх, эм боох зэргээр ажиллахын хамт төвөд үсэг нүдэлж, эмийн нэр гадарлахтайгаа болов. Залуу хөвгүүн 15 настайдаа Нийслэл Хүрээнд хүрч ирж, нэгэн нэртэй маарамбад шавь орж, эрийн цээнд хүрэх буюу эр төөлөх насандаа хүрэхэд “бяцхан” оточийн дөр суужээ. Улмаар “Эмийн дөрвөн үндэс”-ийг гүнзгийрүүлэн судалж, ханах, төөнөх зэрэг эрдэмд шамдан суралцсан байна.

Л.Гомбожав тэжээхүйн ухаанд (анагаах ухаан. Ж.Б) онол, үйлдлэгийн хувьд илтэд гаршсан үедээ Олноо өргөгдсөн Монгол Улсын цэрэгт татагдан алба хааж, улмаар цэргийн оточ болжээ.

Халхын Магсаржав, Баргын Дамдинсүрэн нарыг 1912 онд Ховдын чөлөөлөх болон Хатанбаатар Магсаржавыг хятадын хар цэрэгтэй байлдахад цэргийн отчоор ажилласан байна. Цэргийн хэрэгт ийнхүү хичээнгүйлэн зүтгэсэн Гомбожавыг VIII Богд Жэвзүндамба хаан ихэд үнэлэн, шагнаж хөхүүлж байжээ.

Олноо өргөгдсөний 5 дугаар оны цагаан сарын 11-нд дээш өргөсөн Шашин төр дор туслах Дотоод яамны сайдууд, түшмэлүүдийн гарын үсэг, тамга бүхий зарлигаар хувилгаан ямба шагнагдсан гэлэн Гомбожавыг Тэнгэрийн хишигт мөргүүлмүү хэмээн ирсэн хэрэгт дурьдагдсаныг сийрүүлбэл: “Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа өргөн илгээв. Явуулах учир. Олноо өргөгдсөний 5-р оны цагаан сарын шинийн найманд шашин төр дор туслах сайд Эрдэнэ шанздав (Бадамдорж) нар дор дээд зарлиг буулгасан нь: Шажныг бадруулагч хийдийн цогчин умзад агсан шүтээнийг аймгийн гэлэн Гомбожавт хувилгааны ямба шанагтун хэмээснийг хичээнгүйлэн дагаж үүнийг хувилгааны ямба гэлэн Гомбожавт тушаагаад, буулгасан зарлагийг хичээнгүйлэн дагаж даруй тэнгэрийн хишиг дор мөргөсүгэй. Үүнийг басхүү дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яаман, Нийслэл хүрээний Рэнбуу номон хан эрдэнэ

шанздав над дор нэгэн адил явуулаад, байцаан үзүүлэхээс гадна Дотоод яамнаас хувилгааны ямба, Гомбожавын биеийг авч Тэнгэрийн хишигт мөргүүлэх ажаамуу. Үүний тул өргөн илгээв” гэжээ.

Мөн Олноо өргөгдсөний 7-р оны 3-р сарын 10-нд тусгай жагсаасан нэрийн хуудсанд: “... Их шавийн зайсан түшмэл гутгаар зэрэг Гомбожав нар харъяат сайдуудын дагалдах яаман дор тус тус түшмэлийн албан хааж олон цэргүүдийг сайнаар захиралцаж, элдэв түргэн чухал албаны бичиг сэтгүүл ба элдэв хэрэг дор уран арга, мэргэн бодлогыг хэрэглэж басхүү байлалдан дайралдах зэрэг эл хэрэг дор үнэн санаагаар чармайн зүтгэсэн хэмээсэн нь сайшаалтай тул харъяат сайдын газраас гуйсан ёсоор ... Зайсан түшмэл гутгаар зэрэг жинс Гомбожавт дэд зэрэг жинс Тогосын тус тус шагнахыг гуюумой.

... Цэргийн эмч Түшээт хан аймгийн мөн хошууны хувилгаан ямба, хичээнгүй нягт билэгт цол гэлэн Гомбожав нар бол олон цэргүүдийн тухай аврал унших ба мөн шархадсан, өвдсөнийг сайнаар эмчилж эл хэрэгт зүйл зүйлээр чармайн зүтгэсэн нь сайшаалтай хувилгаан ямба, хичээнгүй нягт билэгт цол гэлэн Гомбожавт хурлын зэд гурван хувь ... Намшиг шар цоохор дэвсгэр тус тус шагнахыг гуймуй.

Түшээт сайн хан аймгийн жанжин жисаанаас дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа хуудсаар өргөн мэдүүлэх учир:

Дотоод хэргийн бүгд захиран шийтгэгч яамнаас ам тушаасныг дагаю. Тус аймгаас баруун, зүүн, өмнө хязгаарт дайлаар мордсон түшмэл цэргүүдийн эмч нараас шагнагдсанаас одоо Нийслэл хүрээний газар буй нь энэ хошууны отог, цол зэргийг ялган салгаж тодорхойлон хуудасны хойно жагсаан бичьюу. Үүний тулд хуудасаар өргөн мэдүүлсүгэй” гэсэн байна. Түүнчлэн 7-р оны 3-р сарын 15-нд жагсаасан нь:

“Түшээт хан аймгийн мэргэн ван Цэсэнжавын хошууны эмч хувилгаан ямба, хичээнгүй нягт билэгт цол гэлэн Гомбожавт хурлын зэд 3 хувь, бас гутгаар зэрэг, цэрэг Цэдэндоржид 7-р зэрэг хэмээснээс бусад нь цөм энд үгүй. Түшээт сайн ханы хошууны дагалдан Гомбожавт 5-р зэрэг, Тогосын отго, сул цэргийн ямба ... шагнасан” тухай мэдээлжээ. Дээр дурьдсан тушаал, зарлигаас үзэхэд, Л.Гомбожав 1911 оны үндэсний хувьсгал, ялангуяа автонолийн засаг тогтсон үед түшмэлийн гутгаар зэрэгтэй, Их шавийн зайсангийн алба, хашиж байжээ. Түүнчлэн оточ маарамбын эрдэмд гарамгай байсны хувьд “Хувилгаан ямба”, түшмэл ёсыг хичээнгүй сахиж, төрийг номын ёсоор засах хэрэгт хоёргүй сэтгэлээр зүтгэсний хувьд “Хичээнгүй нягт билэгт” цол хүртэж, 5

дугаар зэрэг, тогосын отго шагнагдаж байсан байна. Ийнхүү Л.Гомбожавын хичээл зүтгэлийг Монголын төр өндөр үнэлж байв.

Л.Гомбожав 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үзэл санааг талархан хүлээн авчээ. Тэрбээр Д.Сүхбаатарын даалгавараар хувьсгалын хэрэгт оролцож эхэлжээ. Гомбожавынх тэр үед Нийлэл хүрээний усны гудамжинд амьдарч байгаад тусгай даалгавраар одоогийн Борнуурын орчимд гүрэмч ламын дүрээр амьдрах болсон байна. Тэрбээр Нийслэл хүрээ, Алтанбулгийн хооронд дамжих гүүр болж, МАХН-ынхны үйл ажиллагааг дэмжин, орон нутагт ухуулан сурталчилах ажил хийж, цагийн байдлыг судлан мэдээлж байсан аж. Л.Гомбожав охин Цэрэндаваадаа: партизануудад хоол хүнс, хувцас хунар, зэр зэвэг залгуулахын тулд Янжмаа (Сүхбаатарын Ж.Б) хэдэн хүний хамт манайхаар дайран ирж байсан. Тэд үхэр тэргэнд бугын эвэр, арьс шир, түүхий эд цуглуулан очиж, Алтанбулаг явах нэрийдлээр манайд ирэхэд хооллож ундалдаг байсан гэж дурсан ярьж байжээ.

1921 оны хувьсгалын ялалтын дараа Л.Гомбожав Бор нуур хавьдаа (Төв аймгийн Баян-Өлзийт сум) сууршин амьдрах болсон байна. Тэрбээр мал маллахын зэрэгцээ, эмч домчийнхоо ажлыг үргэлжлүүлж, эгэл олон тус үзүүлсээр байжээ. Үр хүүхдүүдээ ч ажилч хичээнгүй болгон хүмүүжүүлж байв. Сайхь оточ хувилгаан олон түмний дотор хүндлэгдэн алдаршсаар 1920-1930-аад оныг ардаа орхисон байна.

Гомбожавын 1938 оны зун Хунцал хэмээх газар зусаж байв. Гэтэл 1938 оны VII сарын 10-нд Дотоод яамны төлөөлөгч ирж, түүнийг баривчилжээ. Баривчлагдсаны дараах хоёр сар гаруйн хугацаанд гэр орон, эд хогшил, мал сүргийг нь гурван удаа хураав. Түүний охин Цэрэндаваагийн тодорхойлж байгаагаар: “Анхны хөрөнгө хураалт эцгийг минь амьд байхад болсон. Лав л алтан нуухтай, шүрэн толгойтой хөөрөг хоёр, хурган дотортой дээл 5, мөнгөн тоногтой эмээл, хазаар тус бүр 4, ээжийн эдэлж байсан 5 цэнгийн алтан ээмэг, 10 лангийн алтан бугуйвч, 3 цэнгийн алтан бөгж хоёр, сувдан даруулга, зүүлт, сувдтай сам, минжин малгай зэрэг ...

Хоёр дахь хөрөнгө хураалт тэр жилийн VIII сард болж, шар үхэр 10, үнээ 16 бүхий 50 гаруй үхэр, 100-аад адуу, 700 гаруй хонь, 12 үхэр тэрэг зүйлүүдийг хураан авчээ. Гуравдахь хөрөнгө хураалтаар дүнзэн байшин (Үүнийг сумын төв рүү зөөж, сургуулийн барилга болгосон), мөнгөн бүслүүртэй 10 л орчмын агар зандан хувин дөрвөн ширхэг, мөнгөн аяга 10 ш, гэрийн бүтэн хивсэн дэвсгэр, улаан цагаан эсгийг бүрээстэй гэр зэргийг хураасан” гэжээ. Үүнээс харахад Гомбожавынх тун чинээлэг айл

V ТҮҮХЭН ТЭМДЭГЛЭЛ, ОРЧУУЛГА, МЭДЭЭ

байсан нь тодорхой. Тэр цагаас хойш эсэргүүний гэр бүл гэж янз бүрээр адлаж, дарамт шахалт үзүүлэх болсон байна.

Жил гаруй болсны дараа түүний эхнэр Цэнгийн Мияа нь Сүхбаатарын Янжмаатай уулзаж зовлонгоо тоочиход, түүнийг Х.Чойбалсантай уулзуулсан байна. Маршал Чойбалсан утсаар эрх мэдэл бүхий хүмүүстэй лавлан ярилцаад, танай нөхөр ЗХУ-д цөлөгдөх ял авч, замдаа нас барсан байна гэсэн гэсэн хариу өгчээ. Тэрбээр:

- Хайран хүн, яагаад бидэнд хэлээгүй юм бэ? гэж холбогдох хүмүүсийг зэмлэж байсан гэдэг. Чойбалсан Л.Гомбожавын гэргийд 1000 төгрөг хадагтай барьж, харамсал илэрхийлжээ.

Ардчилал, шинэчлэлийн ачаар үнэн мөнийг олж, Лувсангийн Гомбожавыг 1938 оны IX сарын 26-ны өдөр Онц бүрэн эрхт комиссын хурлын 33 тогтоолоор цаазлагдсан болохыг тогтоожээ. Л.Гомбожавыг 1993 оны тавдугаар сарын 22-ны өдрийн Монгол Улсын Дээд шүүхийн цэргийн коллегийн 127 дугаар магадлалаар цагаатгаж, гэрчилгээ олгосон байна.

Эдүгээ Г.Гомбожавын охин Цэрэндаваа гуай улс орондоо нэр төртэй хөдөлмөрлөж байгаад, гавъяаныхаа амралтандаа гарчээ. Монголын 1911 оны үндэсний хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан, Г.Гомбожавын нэр төрийг сэргээж, охин Цэрэндаваа болон ач, зээ нарт нь төрөөс хайр халамж үзүүлэх нь зүйд нийцнэ.